

Орхон аймгийн Нийгмийн даатгалын газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн ~~1/27~~ тушаалын 18 дугаар хавсралт

## АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

### I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан  
 Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Нийгмийн даатгалын багц хууль  
(шинэчилсэн найруулга)  
2023-07-07

Дагаж мөрдөх огноо:

2024.01.01

Албан тушаалын тодорхойлолтыг  
баталсан огноо:

2024.06.19

Байгууллагын нэр:

Орхон аймгийн Нийгмийн даатгалын газар

Нэгжийн нэр:

Хамралт, орлогын хэлтэс

Албан тушаалын нэр:

Сайн дурын даатгалын байцаагч,  
мэргэжилтэн

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Дэс түшмэл, ТЗ-9

Ажлын цаг:

Ажлын өдрийн 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

-

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

### II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:


Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, сангийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх, зорилтот бүлгийн иргэдийг сайн дурын даатгалд хамруулах, хамралтыг нэмэгдүүлэх, даатгуулагчдын мэдээллийн санг бүрдүүлэх чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг хэлтсийн даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1.Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө жигд ханган биелүүлэх, зорилтот бүлгийн иргэдийг сайн дурын даатгалд хамруулах, хамралтыг нэмэгдүүлэх, даатгуулагчдын мэдээллийн санг бүрдүүлэх, тайлагнах;

2.Байгууллагын болон нэгжийн дотоод үйл ажиллагааг хэрэгжүүлэх, тайлагнах.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах-Т Гүйцэтгэх-Г Хянах-Х Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Сайн дурын даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг жигд ханган биелүүлэх;	Сайн дурын даатгалын орлогын төлөвлөгөө биелсэн байна.	Г
	2.Сайн дурын даатгуулагчийн мэдээллийг үнэн зөвөөр бүртгэж, мэдээллийн санг бүрдүүлэх;	Даатгуулагч тус бүрийн мэдээллийг үнэн зөв бүртгэсэн байна.	Г
	3.Сайн дурын даатгалын шимтгэл, хугацаа хоцроосон тохиолдолд алдангийг тооцон төлүүлэх, шимтгэлийн ногдуулалт хийх, баталгаажуулах;	Шимтгэлийн ногдуулалтыг тухай бүр хийж, баталгаажуулсан байна.	Г
	4.Нийгмийн даатгалын дэвтэр, хөдөлмөрийн дэвтрийг үндэслэн ажилласан жилийг тооцож сайн дурын даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны тэтгэмж олгох эмнэлгийн хуудсанд тэмдэглэл хийж, баталгаажуулах;	Ажилласан жилийг үнэн зөв тооцож тэмдэглэл хийж, баталгаажуулсан байна.	Г
	5.Сайн дурын даатгуулагчийн урьдчилан төлсөн шимтгэлийн ногдуулалтыг тухай бүр хийх;	Шимтгэлийн ногдуулалтыг үнэн зөв тооцсон байна.	Г
	6.Сайн дурын нийгмийн даатгалын тайлан, мэдээг тухай бүр гаргах;	Тайлан мэдээг цаг хугацаанд нь гаргасан байна.	Г
	7.Хариуцсан ажилтай холбоотой шинэ ажилтан болон нийт ажилтан албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалт, мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах;	Сургалт зохион байгуулж, ажилтнуудын чадавх дээшилсэн байна. Мэдээллийн урсгал сайжирсан байна.	Г
	8.Нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулах, сургалт, сурталчилгаа хийх, пост, контент, постерын санал гаргах;	Хамралт нэмэгдсэн байх, нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн байна.	Г



	9.Сайн дураар даатгуулсан даатгуулагчдад нэрийн дансны талаар мэдээлэл өгч, холбогдох эрх зүйн туслалцаа үзүүлэх;	Журмыг хэрэгжүүлсэн байна.	Г
	10.Нэрийн дансанд хамрагдах иргэд, даатгуулагчийн бүртгэл, судалгаа тооцоог хийх;	Холбогдох хууль журамд нийцсэн байна.	Г
	11.Сайн дурын даатгуулагч, иргэдийн нэрийн дансны мэдээллийг нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан, мэдээллийн санд үндэслэн хянах;	Холбогдох хууль, журмыг хэрэгжүүлсэн байна.	Г
	12.Сайн дурын даатгуулагч, иргэдийн нэрийн дансны мэдээлэл дутуу болон зөрүүтэй, буруу бүртгэгдсэн тооцоог холбогдох баримт нотолгоог үндэслэн хянаж, залруулах арга хэмжээ авах;	Холбогдох журам зааварт нийцсэн байна.	Г
	13.Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн данстай холбоотой мэдээ, тайланг тогтоосон хугацаанд гарган баталгаажуулж, холбогдох албан тушаалтанд хүргүүлэх.	Холбогдох журам зааврыг хэрэгжүүлсэн байна.	Г
2 дугаар зорилтын хүрээнд	1.Нэгжийн үйл ажиллагааны зорилтыг хангахад чиглэсэн өөрийн ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг хангаж ажиллах;	Холбогдох хууль тогтоомжийн дагуу хийсэн байна.	Г
	2.Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг тухай бүр гаргаж өгөх, тайлагнах;	Мэдэгдлийн тухай бүр гаргаж тайлагнасан байна.	Г
	3.Нэгжийн чиг үүрэгтэй холбоотой мэдээ, тайлан, судалгаа гаргах, танилцуулах;	Мэдээ, тайлан, судалгааг үнэн зөв, хугацаандаа гарсан байна.	Г
	4.Албан хэрэг хөтлөлтийн талаарх хууль тогтоомж, баримт бичгийн стандартыг хэрэгжүүлж ажиллах, бүрдүүлсэн баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэн, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу жилийн эцэст архивд хүлээлгэн өгөх;	Холбогдох хууль тогтоомжийн дагуу чиг үүргийг хэрэгжүүлсэн байна.	Г
	5.Иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн санал, хүсэлт, гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах;	Өргөдөл, санал, гомдлыг хууль тогтоомжийн дагуу хугацаанд нь шийдвэрлэсэн байна.	Г
	6.Удирдлагын өгсөн үүрэг, даалгавраар ажил гүйцэтгэх,	Тухай бүр гүйцэтгэж, шаардлагатай тохиолдолд	Г



	танилцуулах, шаардлагатай тохиолдолд ажил орон гүйцэтгэх;	ажил орон гүйцэтгэсэн байна.	
	7.Хөдөлмөрийн дотоод журам, үйл ажиллагааны хүрээнд гарсан бусад дүрэм журам, зааврыг мөрдөж ажиллах;	Дүрэм, журам, зааврыг мөрдөж ажилласан байна.	Г
	8.Олон нийтийн арга хэмжээнд оролцох, зохион байгуулах.	Зохион байгуулагдсан ажилд идэвхтэй оролцсон байна.	Г


### III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх.		
Мэргэжил	<ul style="list-style-type: none"> <li>- эдийн засаг /0311/;</li> <li>- нягтлан бодох бүртгэл, татвар /0411/;</li> <li>- санхүү, банк, даатгал /0412/;</li> <li>- менежмент ба удирдахуй /0413/;</li> <li>- маркетинг, зар сурталчилгаа /0414/;</li> <li>- худалдаа /0416/.</li> </ul>		
Мэргэшил			
Туршлага	Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно.		
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> <li>- Мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх;</li> <li>- Гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах;</li> <li>- Судалгааны ерөнхий арга зүйн мэдлэгтэй.</li> </ul>	
	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> <li>- Өөрийн чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулж, хариуцах;</li> <li>- Шаардлагатай асуудлаар судалгаа хийж, дүнг хариуцах.</li> </ul>	
	Багаар ажиллах	<ul style="list-style-type: none"> <li>- Өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах;</li> <li>- Бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох.</li> </ul>	
	Бусад	<ul style="list-style-type: none"> <li>- Төрийн албан хаагчийн болон Нийгмийн даатгалын байцаагчийн ёс зүйн хэм хэмжээ, үйлчилгээний стандарт, сахилгын тусгай дүрмийг чанд сахин ажиллах, авилга, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;</li> <li>- Албан ажлын чиг үүргийнхээ дагуу хууль эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллах чадвартай байх;</li> <li>- Англи хэл эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах чадвартай байх;</li> <li>- Кирилл болон үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх чадвартай байх;</li> <li>- Компьютерын хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах чадвартай байх.</li> </ul>	

### IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

... аймгийн Нийгмийн даатгалын газрын дарга



<u>Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:</u>	<u>Бусад харилцах субъект:</u> 1. Нийгмийн даатгалын ерөнхий газар; 2. Төрийн болон орон нутгийн захиргааны байгууллага, холбогдох албан тушаалтан; 3. Төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, төсөл, хөтөлбөрийн ажилтан; 4. Иргэн, аж ахуйн нэгж байгууллага.
---	---

**V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ**

<u>Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:</u>	<u>Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:</u>
<u>Албан тушаал:</u> ДОТООД АУДИТ, МОНИТОРИНГИЙН ГАЗРЫН ДАРГА <i>[Signature]</i> ..... Б. ГАНХУЯГ (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)  2024 оны 05 сарын 24-ны өдөр	<u>Байгууллагын нэр:</u> ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ  <u>Шийдвэрийн огноо:</u> 24 05 24 <u>Дугаар:</u> 214

**Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:**

<u>Байгууллагын нэр:</u> <i>[Signature]</i> ..... АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР <u>Шийдвэрийн огноо:</u> 2024-06-19 <u>Дугаар:</u> А/27 (тамга/тэмдэг) <u>ДАРГА:</u> <i>[Signature]</i> (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр) 2024 оны ... дугаар сарын ... -ны өдөр
--

